

БАТЛАВ
ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Н.ПҮРЭВСҮРЭН

2025 оны 02 дугаар сарын 12

“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН
ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР
ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 02 дугаар сарын 12

Дугаар 03

Налайх дүүрэг

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурал 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 15:30 цагт Налайх дүүрэг 3 дугаар хороо, паркийн гүйцэтгэх захирлын өрөөнд болно.

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа /минут/	Асуудал танилцуулах албан тушаалтан	Гарах шийдвэр
1	Байгууллагын 0012УНА дугаартай, Соната-6 маркийн тээврийн хэрэгслийг данснаас хасах тухай	30	Зөвлөлийн дарга	Тэмдэглэл

НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН
ӨМЧ ХАМГААЛАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025.02.12.

Налайх дүүрэг

Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн дэргэдэх өмч хамгаалах зөвлөлийн хурлыг газрын даргын өрөөнд 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 15:30 цагт эхэлж 16:00 цагт дуусгав. Хуралд өмч хамгаалах зөвлөлийн дарга Н.Пүрэвсүрэн гишүүд Э.Энгүүн, О.Чулуун-Эрдэнэ, Г.Ганцэцэг нар болон нярав Э.Ундармаа нар оролцов. Хурлын ирц 100 хувь.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: Байгууллагын 0012УНА дугаартай, Соната-6 маркийн тээврийн хэрэгслийг данснаас хасах тухай

СОНССОН НЬ: Нийслэлийн Засаг даргын 2024 оны 12 сарын 30-ны өдрийн А/1544 тоот захирамжид Нийслэлийн өмчит байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй сэргээн засварлаж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй, техникийн комиссын дүгнэлтээр цаашид ашиглах боломжгүй нь тогтоогдсон, үлдэх өртөггүй тээврийн хэрэгслийг данснаас хасахыг эзэмшигч байгууллагад зөвшөөрсүгэй гэжээ. Уг захирамжийн 1 дүгээр хавсралтад байгууллагын 0012УНА дугаартай, Соната-6 маркийн тээврийн хэрэгслийг дурджээ.

Н.Пүрэвсүрэн: Дээрх захирамжийн дагуу өнөөдөр Нийслэлийн Өмчийн харилцааны газрын ХАХХА мэргэжилтэн Г.Төмөр ирж 0012УНА тээврийн хэрэгслийг бичиг баримтын хамт хүлээн авсан. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2025 оны 01 сарын 03-ны өдрийн 01 дүгээр хуралдаанаар бид актлуулах санал гаргасан. Тэр үед гишүүд бүгд өөрсдийн саналаа өгсөн. Нэмж санал гаргах гишүүн байна уу?

Г.Ганцэцэг: Нэмэх санал байхгүй. Цаашид ашиглах боломжгүй тээврийн хэрэгслийг байгууллагын данснаас хасч, акталж байгаа нь маш зөв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: 0012 УНА дугаартай авто тээврийн хэрэгслийг байгууллагын данснаас хасах. Автомашин хүлээлцсэн актыг үйлдэж, гарын үсэг зуруулахыг захиргааны мэргэжилтэн Д.Номин-Эрдэнэ-д, тус актыг үндэслэн байгууллагын данснаас журмын дагуу хасахыг нярав Э.Ундармаад үүрэг болгов.

Өмч хамгаалах комиссын

Дарга

Гишүүд



Н.Пүрэвсүрэн /Төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга/

Э.Энгүүн /Маркетингийн мэргэжилтэн/

О.Чулуун-Эрдэнэ /Гадаад харилцаа, хамтын ажиллагааны мэргэжилтэн/

Г.Ганцэцэг /Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга/

Э.Ундармаа /Нярав/